



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР


14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020.02.20 № 271  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ГАЗРЫН ДАРГА, ТӨСВИЙН ШУУД  
ЗАХИРАГЧ Д.БАТСҮХ ТАНАА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын  
тайлан, гэрчилгээг хүргүүлж байна.

Хавсралт: 2 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Б.МӨНХ-ОЧИР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020.02.20 № 272  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ГАЗРЫН ДАРГА, ТӨСВИЙН ШУУД  
ЗАХИРАГЧ Д.БАТСҮХ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон


удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын Стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Б.МӨНХ-ОЧИР



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: НТАГ-2020/264/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2020 он

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: Ц.Бат-Өлзий  
Утас: 327734 Цахим хаяг: bat-ulziits@audit.gov.mn  
Аудитын менежер: А.Цогбаяр  
Утас: 315558 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn  
Аудитор: Ц.Батсүх  
Утас: 325093 Цахим хаяг: batsukhts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НЗД	Нийслэлийн Засаг дарга
ҮИБНЗБХ	Үндэсний Их баяр наадам зохион байгуулах хороо
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТШЗ	Төсвийн шууд захирагч

**Агуулга**

1.Аудитын гэрчилгээ .....	3
2.Аудитын тайлан.....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	8
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3.Менежментийн захидал .....	10
4.Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	14
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	16
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	17
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	18

## 1.Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020.01.20 № 22  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ГАЗРЫН ДАРГА, ТӨСВИЙН ШУУД  
ЗАХИРАГЧ Д.БАТСҮХ ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон

D:\Documents\Documents\2020 on\ywuulsan bichig\2020 02.20 N-AJG.docx


удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын Стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Б.МӨНХ-ОЧИР



## 2.Аудитын тайлан

### 2.1. Оршил

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Д.Батсүхэд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 20-наас 2020 оны 2 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, НТАГ-ын аудитор Ц.Батсүх хариуцаж хэрэгжүүлэв.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг НТАГ-т 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/29 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь *"Нийслэл Улаанбаатар хотыг гадаадын жуулчин хүлээн авах хүчин чадал, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ бүхий хот болгон хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлнэ."* гэж тодорхойлсон байна.

Тус газар нь 2019 онд "Салбарын хүний нөөцийг чадавхжуулах" үндсэн зорилт тавин ажиллажээ. Уг зорилго, зорилтыг ханган биелүүлэхийн тулд нийт 2 зорилт бүхий 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт гараагүй байна.

### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Нийслэлийн Аялал жуулчлалын газар нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Нийслэлийн Аялал жуулчлалын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 34 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны нийт зардлын урьдчилсан гүйцэтгэлийн дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийг өмнөх оны зардлын дүн нийт 1,293,670.0 мянган төгрөгөөс тооцон 25,874.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 17,633.9 мянган төгрөгөөр тооцсон нь нийт зардлын дүн өмнөх оноос 46.7 хувиар буурсантай холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн 31,003.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд материаллаг өөрчлөлт гарсан данс байхгүй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	33.98	33.98	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	97 683.32	108 717.00	11 033.68
Үндсэн хөрөнгө	33 020.65	52 990.41	19 969.76
Үндсэн хөрөнгө	120 619.37	155 064.37	34 445.00
Хуримтлагдсан элэгдэл	(87 598.71)	(102 073.96)	(14 475.24)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>130 737.95</b>	<b>161 741.39</b>	<b>31 003.43</b>
Өр төлбөр	84.72	84.72	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	130 653.23	161 656.67	31 003.43
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>130 737.95</b>	<b>161 741.39</b>	<b>31 003.43</b>

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 34,445.0 мянган төгрөгөөр өссөн нь тайланд Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас үнэ төлбөргүй хөрөнгө шилжиж ирсэнээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 33,983.4 мянган төгрөг байгаа нь 2017 онд ажилаас чөлөөгдсөн албан хаагчидтай /холбогдох эзэн төлөөлөгч нь тодорхой бус/ холбоотой байна.

Тайлант онд Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас хандиваар буюу үнэ төлбөргүйгээр 2,597.4 мянган төгрөгний бараа материал хүлээн авсантай холбоотой байна.

Өглөг дансны үлдэгдэл 84.6 мянган төгрөг байгаа нь өнгөрсөн оны өглөг барагдаагүйтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 31,003.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд ТШЗ-ийн нийт 350,402.8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 280,902.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр үндсэн үйл ажиллагааны орлого 5,000.0 туслах үйл ажиллагааны орлого 66,500.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн болно.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 289,669.4 мянган төгрөг буюу 82.7 хувьтай байгаа нь үндсэн цалингаас 561.6 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлаас 2,423.2 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрөөс 57,131.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлаас 617.1 мянган төгрөгөөр, нэг удаагийн шагнал урамшууллын зардлаас 80.0 мянга, нийт 60,813.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалжээ.

**Нэмэлт төсөв:** НЗДТГ, НИТХ болон ҮИБНЗБХ-оос нийт 577,924.7 мянган төгрөгийн орлогын бүрдүүлжээ. Үүнээс 577,924.7 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан.

### **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 34 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд нэмж эрсдэл илрээгүй 17 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 61,118.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 45,478.7 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 15,639.9 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгаж хүргүүллээ.

### **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Тус байгууллагын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй материаллаг эрсдэлтэй асуудал гараагүй болно.

### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Нийслэлийн Аялал жуулчлалын газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 24 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

### **2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан боловч авлага, өглөгийг бүрэн барагдуулаагүй байна.

#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

##### **“Зөрчилгүй” дүгнэлт**

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### Зардалтай холбоотой асуудал

##### 1.1 Илрүүлэлт:

- Тайлант хугацаанд цахим И баримтын дүнгээс зөрүүтэй 11,138.5 мянган төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн. Энэ нь үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.3.2."бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалтуудыг зөрчсөн.

##### 1.2 Эрсдэл:

- Ажил гүйлгээний дүн анхан шатны баримтын дүнгээс зөрүүтэй байх;
- Бараа материалын нэр төрөл, тоо хэмжээ, нэгжийн үнэ тодорхойгүй бүртгэх;

##### 1.3 Өгсөн зөвлөмж:

- Анхан шатны үнэн зөв баримтад /цахим И баримт/ үндэслэн төлбөр шилжүүлж байх;

#### 1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

- ТШЗ-ийн зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 5 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

#### Балансын данстай холбоотой асуудал

##### 2.1 Илрүүлэлт:

- Цалингийн өглөгийн дүнгээс олгохоор тооцсон цалин 4,382.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн. Энэ нь үнэн зөв, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаалын Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягтыг хөтлөх аргачлал хавсралтын 6.5.1."Ажиллагчдын цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэл ЦХ-1 "... ажиллагсдын үндсэн цалин, нэмэгдэл цалин (зэрэг дэвийн нэмэгдэл, илүү цаг, удаан жилийн нэмэгдэл гэх мэт) болон олгохоор тооцсон цалинг бүртгэнэ. Олгохоор тооцсон цалин хөлсний дүнг цалингийн өглөг дансны кредитэд бичнэ." заалтыг хэрэгжүүлээгүй.

##### 2.2 Эрсдэл:

- Цалингийн зардлыг зохих журмын дагуу бүртгэж тайлагнаагүй байх, хууль, журам хэрэгжихгүй байх.

##### 2.3 Өгсөн зөвлөмж:

- Цалингийн дэлгэрэнгүй бүртгэлийн дагуу журналд бичилт хийж байх, цалингийн урьдчилгаа олгохдоо сэлгэн ажиллах тушаал, шийдвэртэй уялдуулах, улмаар НБББББ-т тусган мөрдөх, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

#### 2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

- ТШЗ-ийн зүгээс зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар хариу ирүүлсэн.

#### 3 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

##### 3.1 Илрүүлэлт:

- Хувь хүмүүсээс авах он удаан жил болсон авлагын 33.6 мянган төгрөг, өглөгийн 87.7 мянган төгрөгийн нийт 118.6 мянган төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, авлага, өглөгийг барагдуулах арга хэмжээ аваагүй. Энэ нь бодитой оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5."дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах";20.2.6."эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"; заалтуудыг хэрэгжүүлээгүй.

##### 3.2 Эрсдэл:

- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

##### 3.3 Өгсөн зөвлөмж:

- Авлагын үлдэгдлийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авах;

### 3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:


- ТШЗ-ийн зүгээс зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### АУДИТЫН ТАЙЛАНГ

Хянасан:

Санхүүгийн аудитын хэлтсийн дарга  
бөгөөд аудитын менежер



Ц.Бат-Өлзий

Аудитын менежер

А.Цогбаяр

Бэлтгэсэн:

Аудитор



1117145633  
УХА0612 9077278

Ц.Батсүх



Үйлчлүүлэгч байгууллагын хариу:



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,  
Ж.Самбуулын гудамж, Бага тогруу 15,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас/факс: 7012-6667  
E-mail: info@tourism.ub.gov.mn  
http://www.tourism.ub.gov.mn

2020.02.20 № 01/65  
Танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ

Танай газраас ирүүлсэн "асуудлын бүртгэлийн дагуу санхүүгийн тайлангийн цахим и-баримтын дүнгээс зөрөөтэй төлбөр шилжүүлсэн" гэх зөвлөмжийн дагуу залруулга хийж Нийслэлийн Аялал жуулчлалын газраас худалдан авсан гэрээт ажил үйлчилгээг хавсралтаар хүргүүлээ.

Цаашид Татварын ерөнхий газрын даргын 2019 оны 12 сарын 30-ны өдрийн А/260 тоот тушаалаар батлагдсан "Татварын тайлан үйлдэх, тушаах, хүлээн авах, боловсруулах, залруулга хийх" журмын 4 дүгээр зүйл заалтын дагуу тайлангийн залруулга хийлгэх и-баримтын зөрчлийг арилгаж ажиллана.  
Хавсралт 1 хуудастай.

ДАРГА *Б.Батцэцэг* БАТЦЭЦЭГ



1150500638

E:\NAJG\2020\lban bichig A5\2020.02.20 01-65 T.Tyul, B.Batcyr docx

**4.Аудит хийгдсэн санхүүгийн тайлан**

**4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Балаасын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>97 717 302.84</b>	<b>108 750 980.84</b>
<b>АВЛАГА</b>		
Бусад авлага	33 983.84	33 983.84
Байгууллагаас авах авлага	33 983.84	33 983.84
Хувь хүмүүсээс авах авлага	21 467.84	21 467.84
Хувь хүмүүсээс авах авлага	12 516.00	12 516.00
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>97 683 319.00</b>	<b>108 716 997.00</b>
<b>Түүхий эд материал</b>	<b>37 788 050.00</b>	<b>48 155 300.00</b>
Тусгай зориулалттай материал	37 788 050.00	48 155 300.00
<b>Хангамжийн материал</b>	<b>59 895 269.00</b>	<b>60 561 697.00</b>
Бичиг хэргийн материал	6 291 743.00	1 867 799.00
Аж ахуйн материал	2 816 395.00	6 398 600.00
Сэлбэг хэрэгсэл	250 100.00	2 492 578.00
Түлш, шатах тослох материал	3 356 800.00	936 000.00
Бусад хангамжийн материал	47 180 231.00	48 866 720.00
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>33 020 651.45</b>	<b>52 990 406.88</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>33 020 651.45</b>	<b>52 990 406.88</b>
<b>Биет хөрөнгө</b>	<b>15 074 651.45</b>	<b>41 192 906.88</b>
Машин тоног төхөөрөмж (компьютер)	51 982 566.00	53 167 566.00
Хуримтлагдсан элэгдэл	(44 225 589.19)	(48 497 289.52)
Тавилга, аж ахуйн эд хогшил	32 802 800.00	64 102 800.00
Хуримтлагдсан элэгдэл	(25 874 014.12)	(29 344 169.58)
Бусад үндсэн хөрөнгө	5 000 000.00	6 960 000.00
Хуримтлагдсан элэгдэл	(4 611 111.24)	(5 196 000.02)
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>17 946 000.00</b>	<b>11 797 500.00</b>
Програм хангамж	30 834 000.00	30 834 000.00
Хуримтлагдсан элэгдэл	(12 888 000.00)	(19 036 500.00)
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>130 737 954.29</b>	<b>161 741 387.72</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>84 720.64</b>	<b>84 720.64</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>84 720.64</b>	<b>84 720.64</b>
<b>Өглөг</b>	<b>84 720.64</b>	<b>84 720.64</b>
Ажилчидтай холбогдсон өглөг	26 283.64	26 283.64
<b>Бусад өглөг</b>	<b>58 437.00</b>	<b>58 437.00</b>
Байгууллагад төлөх өглөг	58 437.00	58 437.00
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>130 653 233.65</b>	<b>161 656 667.08</b>
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>130 653 233.65</b>	<b>161 656 667.08</b>
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	60 000 000.00	60 000 000.00
Өмч:- төрийн	60 000 000.00	60 000 000.00
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>70 653 233.65</b>	<b>101 656 667.08</b>
Өмнөх үеийн үр дүн	70 653 233.65	70 653 233.65
Тайлант үеийн үр дүн	-	31 003 433.43
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>130 737 954.29</b>	<b>161 741 387.72</b>

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1 244 593 712.72</b>	<b>912 700 638.00</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5 716 159.83</b>	<b>53 873 155.00</b>
<b>Нийтлэг татварын бус орлого</b>	5 716 159.83	53 873 155.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого	5 716 159.83	53 873 155.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	6 123 190.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5 513 359.83	10 707 487.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	202 800.00	37 042 478.00
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>1 238 877 552.89</b>	<b>858 827 483.00</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1 000 506 652.89	577 924 683.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	989 170 332.89	577 924 683.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11 336 320.00	-
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	238 370 900.00	280 902 800.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	238 370 900.00	280 902 800.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1 293 670 038.22</b>	<b>881 697 204.57</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1 293 670 038.22</b>	<b>881 697 204.57</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1 253 731 319.58	873 633 136.34
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	216 485 571.14	241 434 949.00
Үндсэн цалин	183 059 921.14	241 434 949.00
Нэмэгдэл	18 989 650.00	-
Унаа хоолны хөнгөлөлт	14 436 000.00	-
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	27 421 381.75	31 867 550.00
Тэтгэврийн даатгал	18 852 764.74	22 262 769.00
Тэтгэмжийн даатгал	2 341 295.79	2 619 152.00
ҮОМШӨ-ний даатгал	1 734 797.83	1 959 641.00
Ажилгүйдлийн даатгал	408 410.49	456 908.00
Эрүүл мэндийн даатгал	4 084 112.90	4 569 080.00
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	4 584 000.00
Байрны түрээс	-	4 584 000.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17 139 517.05	14 335 206.77
Бичиг хэрэг	5 285 447.00	4 758 330.00
Тээвэр, шатахуун	4 933 971.00	5 286 491.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4 230 562.05	4 290 385.77
Бараа материал акталсны зардал	2 689 537.00	-
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	975 582 595.30	515 203 286.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	974 466 595.30	511 366 486.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1 116 000.00	3 836 800.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	17 102 254.34	66 208 144.57
Бараа үйлчилгээний бусад зардал	942 600.00	51 332 900.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	400 000.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16 159 654.34	14 475 244.57
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	39 938 718.64	8 064 068.23
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	24 618 800.00	1 920 000.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22 618 800.00	-

**Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2 000 000.00	1 920 000.00
<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>15 319 918.64</b>	<b>6 144 068.23</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг	15 319 918.64	6 144 068.23
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(49 076 325.50)</b>	<b>31 003 433.43</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>76 000.00</b>	<b>-</b>
Үнэ төлбөргүй гарсан зардал	76 000.00	-
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(76 000.00)</b>	<b>-</b>
<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(49 152 325.50)</b>	<b>31 003 433.43</b>

### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1 244 224 642.89</b>	<b>875 658 160.00</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5 347 090.00</b>	<b>16 830 677.00</b>
<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>5 347 090.00</b>	<b>16 830 677.00</b>
<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>5 347 090.00</b>	<b>16 830 677.00</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	6 123 190.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5 347 090.00	10 707 487.00
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1 238 877 552.89</b>	<b>858 827 483.00</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1 000 506 652.89</b>	<b>577 924 683.00</b>
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	989 170 332.89	577 924 683.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11 336 320.00	-
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>238 370 900.00</b>	<b>280 902 800.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	238 370 900.00	280 902 800.00
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1 244 224 642.89</b>	<b>875 658 160.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1 244 224 642.89</b>	<b>875 658 160.00</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1 204 285 924.25</b>	<b>867 594 091.77</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>169 785 761.31</b>	<b>197 013 582.00</b>
Үндсэн цалин	126 982 661.31	149 362 682.00
Нэмэгдэл	29 299 500.00	25 870 900.00
Унаа хоолны хөнгөлөлт	13 503 600.00	21 780 000.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>20 536 600.00</b>	<b>24 697 000.00</b>
Тэтгэврийн даатгал	14 968 800.00	16 793 900.00
Тэтгэмжийн даатгал	578 400.00	1 975 800.00
ҮОМШӨ-ний даатгал	1 330 500.00	1 580 600.00
Ажилгүйдлийн даатгал	332 600.00	395 200.00
Эрүүл мэндийн даатгал	3 326 300.00	3 951 500.00
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>-</b>	<b>4 584 000.00</b>
Байрны түрээс	-	4 584 000.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14 814 630.05</b>	<b>14 154 156.77</b>
Бичиг хэрэг	5 650 097.00	4 585 080.00
Тээвэр, шатахуун	4 933 971.00	5 159 691.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4 230 562.05	4 409 385.77
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>998 176 332.89</b>	<b>575 412 453.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	997 060 332.89	571 575 653.00

**Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1 116 000.00	3 836 800.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	972 600.00	51 732 900.00
Бараа үйлчилгээний бусад зардал	972 600.00	51 332 900.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	400 000.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>39 938 718.64</b>	<b>8 064 068.23</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	24 618 800.00	1 920 000.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22 618 800.00	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2 000 000.00	1 920 000.00
<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	15 319 918.64	6 144 068.23
Төвлөрүүлэх шилжүүлэг	15 319 918.64	6 144 068.23
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

**4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	60 000 000.00	0.00	119 805 559.15	179 805 559.15
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>60 000 000.00</b>	<b>0.00</b>	<b>119 805 559.15</b>	<b>179 805 559.15</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-49 152 325.50	-49 152 325.50
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>60 000 000.00</b>	<b>0.00</b>	<b>70 653 233.65</b>	<b>130 653 233.65</b>
<b>2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>60 000 000.00</b>	<b>0.00</b>	<b>70 653 233.65</b>	<b>130 653 233.65</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>60 000 000.00</b>	<b>0.00</b>	<b>70 653 233.65</b>	<b>130 653 233.65</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт,бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	31 003 433.43	31 003 433.43
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>60 000 000.00</b>	<b>0.00</b>	<b>101 656 667.08</b>	<b>161 656 667.08</b>

**4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	350 402 800.00	293 226 208.77	57 176 591.23	83.68
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	350 402 800.00	293 226 208.77	57 176 591.23	83.68
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	350 402 800.00	293 226 208.77	57 176 591.23	83.68
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	197 575 200.00	197 013 582.00	561 618.00	99.72
Үндсэн цалин	149 924 300.00	149 362 682.00	561 618.00	99.63

**Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Нэмэгдэл	25 870 900.00	25 870 900.00	-	100.00
Унаа хоолны хөнгөлөлт	21 780 000.00	21 780 000.00	-	100.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	24 697 000.00	28 253 800.00	(3 556 800.00)	114.40
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	4 584 000.00	4 584 000.00	-	100.00
Байрны түрээс	4 584 000.00	4 584 000.00	-	100.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16 577 400.00	14 154 156.77	2 423 243.23	85.38
Бичиг хэрэг	6 677 400.00	4 585 080.00	2 092 320.00	68.67
Тээвэр, шатахуун	5 100 000.00	5 159 691.00	(59 691.00)	101.17
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4 800 000.00	4 409 385.77	390 614.23	91.86
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	104 969 200.00	47 837 770.00	57 131 430.00	45.57
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100 969 200.00	44 000 970.00	56 968 230.00	43.58
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4 000 000.00	3 836 800.00	163 200.00	95.92
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2 000 000.00	1 382 900.00	617 100.00	69.15
Бараа үйлчилгээний бусад зардал	1 000 000.00	982 900.00	17 100.00	98.29
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1 000 000.00	400 000.00	600 000.00	40.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	352 402 800.00	297 733 477.00	54 669 323.00	84.49
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	280 902 800.00	280 902 800.00	-	100.00
Орон нутгийн төсвөөс	280 902 800.00	280 902 800.00	-	100.00
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	71 500 000.00	16 830 677.00	54 669 323.00	23.54
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5 000 000.00	6 123 190.00	(1 123 190.00)	122.46
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	66 500 000.00	10 707 487.00	55 792 513.00	16.10
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	18.00	18.00	-	100.00
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00	-	100.00

**4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>577 924 683.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>577 924 683.00</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	577 924 683.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	527 574 683.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	527 574 683.00
Бараа үйлчилгээний бусад зардал	50 350 000.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>577 924 683.00</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>577 924 683.00</b>
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	577 924 683.00